



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 18

Мандалговь

**Г.Энхдэлгэрийг Эрдэнэдалай сумын Засаг
даргын Тамгын газрын даргын албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Галбаатарын Энхдэлгэр 62.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Г.Энхдэлгэрийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын даргын
албан тушаалд нэр дэвшүүлсэн Г.Энхдэлгэрийн тухай
дүгнэлт**

1. Г.Энхдэлгэр нь 1975 онд Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд төрсөн. 47 настай, эмэгтэй
2. Боловсрол: 1992-1995 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг экологич, байгаль хамгаалагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 1996-2011 онд Эрдэнэдалай сумын ЗДТГ-т байгаль орчин, газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн, 2011-2017 онд Тамгын газрын дарга, 2020 оноос Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
4. Г.Энхдэлгэрийн төрийн албаны туршлага болон тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.